



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 7 дугаар сарын 9-ний өдөр

Дугаар 225

Улаанбаатар хот

МАЛ, АМЬТНЫ ГОЦ ХАЛДВАРТ, ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 11.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт оношлогдсон Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний олон улсын худалдаанд хориг саад үүсгэдэг гоц халдварт, халдварт өвчин, хүний амь нас хохирох эрсдэл үүсгэдэг зооноз өвчний жагсаалтыг 1 дүгээр хавсралт, Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний дотоодын худалдаанд хориг саад үүсгэдэг гоц халдварт, халдварт өвчний жагсаалтыг 2 дугаар хавсралт, Бусад халдварт өвчний жагсаалтыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

(Энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад Засгийн газрын 2021 оны 302 дугаар тогтоолоор нэмэлт орсон)

2. Энэ тогтоолын хавсралтад заасан мал, амьтны гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, гоц халдварт, халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээг холбогдох хууль, заавар, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзоригт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД У.ХҮРЭЛСҮХ

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД Б.БАТЗОРИГ

ЗАСГИЙН ГАЗРЫН 2018 ОНЫ 225 ДУГААР

ТОГТООЛЫН 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ МАЛ, АМЬТАН, ТЭДГЭЭРИЙН
ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ
ОЛОН УЛСЫН ХУДАЛДААНД ХОРИГ СААД ҮҮСГЭДЭГ ГОЦ ХАЛДВАРТ,
ХАЛДВАРТ ӨВЧИН, ХҮНИЙ АМЬ НАС ХОХИРОХ ЭРСДЭЛ
ҮҮСГЭДЭГ ЗООНОЗ ӨВЧНИЙ ЖАГСААЛТ

1. БОГ МАЛЫН МЯЛЗАН

2. ШҮЛХИЙ
3. БООМ
4. ХОНЬ, ЯМААНЫ ЦЭЦЭГ
5. ГАХАЙН СОНГОМОЛ МЯЛЗАН
6. ӨНДӨР ХОРУУ ЧАНАРТАЙ ШУВУУНЫ ТОМУУ
7. БРУЦЕЛЛЁЗ
8. ЯМААНЫ ГОДРОН
9. ҮХРИЙН МЯЛЗАН
10. ҮХРИЙН ЦЭЭЖ
11. ГАЛЗУУ
12. ЯМ
13. ХОРТ САЛСТ ХАЛУУРАЛ
14. ШУВУУНЫ ТАХАЛ
15. ХӨХ ХЭЛТЭХ
16. СҮРЬЕЭ
17. ЛИСТЕРИОЗ
18. ҮХРИЙН АРЬС ТОВРУУТАХ (ЗАСГИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ 302 ДУГААР ТОГТООЛООР НЭМСЭН)

ЗАСГИЙН ГАЗРЫН 2018 ОНЫ 225 ДУГААР

ТОГТООЛЫН 2 ДУГААР ХАВСРАЛТ МАЛ, АМЬТАН, ТЭДГЭЭРИЙН
ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ
ДОТООДЫН ХУДАЛДААНД ХОРИГ СААД ҮҮСГЭДЭГ ГОЦ ХАЛДВАРТ,
ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ЖАГСААЛТ

1. ДУУТ ХАВДАР
2. ЦУСАН ХАЛДВАР
3. ДОТРЫН ХАЛДВАРТ ХОРДЛОГО
4. ИЖ БАЛНАД
5. БОТУЛИЗМ
6. ГАХАЙН ҮРЖИЛ, АМЬСГАЛЫН ХАМ ШИНЖ
7. ҮХРИЙН РИНОТРАХЕЙТ
8. ҮХРИЙН ДИАРЕЙ
9. ҮХРИЙН ЛЕЙКОЗ
10. ИЖ СҮРЬЕЭ
11. АДУУНЫ ВИРУСЫН АРТРИТ
12. БАРУУН НИЛИЙН ХАЛДВАР
13. АДУУНЫ ХАЛДВАРТ ЦУС БАГАДАХ
14. НИЙЛҮҮЛГИЙН ӨВЧИН
15. ТЭМЭЭНИЙ АМРУУ
16. МАЕДИ ВИСНА
17. СУЛ ХОРУУ ЧАНАРТАЙ ШУВУУНЫ ТОМУУ
18. АДЕНОМАТОЗ
19. ЗОГСОО
20. ЛЕПТОСПИРОЗ
21. ЭНТЕРОБАКТЕРИОЗ
22. ТУЛЯРЕМИ

23. КУ ЧИЧРЭГ
 24. КАМПИЛОБАКТЕРИОЗ
 25. ГАХАЙН ЁЛОМ
 26. ХАЧИГТ ЭНЦЕФАЛИТ
 27. ХОНИНЫ ЭНЗООТ ЗУЛБАХ
- ООО-----

СГИЙН ГАЗРЫН 2018 ОНЫ 225 ДУГААР

ТОГТООЛЫН 3 ДУГААР ХАВСРАЛТ БУСАД ХАЛДВАРТ ӨВЧНИЙ
ЖАГСААЛТ

1. КОЛИБАКТЕРИОЗ
2. СОХОР ДОГОЛ
3. ГҮҮНИЙ ИЖ БАЛНАД
4. САХУУ
5. ШӨВӨГ ЯР
6. ХУЛГАНА ЯР
7. АДУУНЫ ХАЧГИЙН ХАЛУУН
8. ШУВУУНЫ ГАМБОРА
9. МАРЕКИЙН ӨВЧИН
10. НОХОЙ, МУУРНЫ ПАРВОВИРУСЫН ХАЛДВАР
11. АДУУНЫ ПНЕВМОНИ
12. НЕКРОБАКТЕРИОЗ
13. ДЭЛЭНГИЙН ӨМРӨӨ
14. ХАЧИГТ РИККЕТСИОЗ
15. ГАХАЙН МИКСОПЛАЗМОЗ
16. ГАХАЙН САЛЬМОНЕЛЛЁЗ
17. ШУВУУНЫ МИКСОПЛАЗМОЗ
18. ШУВУУНЫ ПУЛЛЮРОЗ
19. ШУВУУНЫ СҮРЬЕЭ
20. ШУВУУНЫ ЛАРИНГОТРАХЕЙТ
21. ЗӨГИЙН ҮЖИЛ
22. ТУУЛАЙН ВИРУСТ ЦУСАН ХАЛДВАР
23. ТУУЛАЙН МИКСОМАТОЗ